

УСНЫ КОМПАКТ

Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал

Б.Батсүх: Монголд анх удаа микротуннелингийн аргаар гол доогуур шугам хоолой тавих сүвлэгээ хийлээ

Туул голын доогуурх хөндлөн сүвлэгээний ажлын талаар Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал Б.Батсүхээс тодруулав.

-Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах, шугам хоолой суурилуулах ажлын хүрээнд Туул голын доогуур сүвлэгээ хийх ажлыг амжилттай гүйцэтгэсэн байна. Баяр хүргэе. Энэ сүвлэгээ юугаараа онцлог ажил байсан бэ?

-Баярлалаа. Энэ төслийн хүрээнд төмөр зам, гол, авто зам доогуур нийт 20 сүвлэгээний ажил хийхээр төлөвлөсөн байгаа. Үүнээс дөрвийг нь микротуннелингийн аргаар гүйцэтгэнэ. Хоёрыг нь Биокомбинатын эх үүсвэрийн талбайд, үлдсэн хоёрыг Шувууны талбайд. Өнөөдрийн байдлаар Биокомбинатын талбайн эхний сүвлэгээний хос микро туннелийн нэгийг нь өрөмдөж дууссан.



Үргэлжлэл 2-р нүүрт

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн туршилт, тохируулга эхэллээ

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалт, хяналт удирдлагын СКАДА системийн суурилуулалтын ажил 93.9 хувьд хүрээд байна. Барилга угсралтын ажил дуусч байгаатай

холбогдуулан үйлдвэрийн тоног төхөөрөмжийн туршилт, тохируулгын эхний үе шатыг 2025 оны 4 дүгээр сарын

Үргэлжлэл 2-р нүүрт

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 75.4%-д хүрэв

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд барьж байгуулж буй технологийн 9, бусад 8, нийт 17 байгууламжийн барилга угсралтын ажил 75.4%-ийн гүйцэтгэлтэй

Үргэлжлэл 3-р нүүрт

Усны үйлчилгээний хэрэглэгчийн мэдээллийн сан бүхий системийн альфа хувилбарыг хөгжүүлэв

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хэрэглэгчдэд үзүүлэх цахим үйлчилгээг сайжруулах төслийн ажлын хүрээнд усны үйлчилгээний хэрэглэгчийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт

Үргэлжлэл 4-р нүүрт



УСУГ-ын инженер, техникийн ажилтнуудад зориулсан онол, дадлагын сургалт эхэллээ

Үргэлжлэл 3-р нүүрт

ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим шоо метрээр нэмэгдэх юм.

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн туршилт тохируулга эхэллээ



Түрүүч нь 1-р нүүрт

9-ний өдөр эхлүүлээ. Үйлдвэрийн туршилт, тохируулга гурван үе шаттай үргэлжилнэ. Тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг шалгах эхний шатны туршилт, тохируулга 5 дугаар сарын сүүлчээр дуусах бол хоёр дахь үе шат 6 дугаар сард эхлэх бөгөөд энэ үеэр үйлдвэр анхны усаа хүлээж авна.

Товчхон

- “МАПА Иншаат ве Тижарет” компани нэмэлт ажлын даалгаврын хүрээнд нийт 13 км ус дамжуулах шугам хоолойн угсралтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд нийт гүйцэтгэл 80.28%-тай явж байна.

- Газрын доорх усны эх үүсвэрийн худгууд, ус дамжуулах шугам хоолойн барилга угсралтын ажлын хүрээнд “Баран групп”-ын гүйцэтгэж буй нийт ажлын гүйцэтгэл 68.8%-тай байна. Үүнд,

44.4%

Биокомбинатын эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил

37.6%

Шувуун эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил

93.4%

Шувуун дамжуулах шугам хоолойн болон хаалтын худаг

46.1%

Төслийн нийт сүвлэгээний ажил

56.0%

Шилэн кабель

Б.Батсүх: Монголд анх удаа микротуннелингийн аргаар гол доогуур шугам хоолой тавих сүвлэгээ хийлээ

Түрүүч нь 1-р нүүрт

Нэг захаасаа нөгөө зах хүртлээ голын доогуур нийт 238 метр газар өрөмдлөг хийгдээд гарсан. Энэ нь Монголд гол доогуур микротуннелингийн аргаар сүвлэгээ хийсэн анхны туршлага болж байна. Манайд ихэвчлэн хийн цохилтот өрөмдлөгийн аргаар төмөр зам юм уу, авто зам доогуур сүвлэгээ хийдэг.

-Микротуннелингийн аргын энгийнээр тайлбарлавал?

-Метро барих газрыг том машинаар өрөмдөж, ухаж туннель гаргадаг даа. Тэр машины л жижигрүүлсэн хувилбарыг ашиглаж, 1400мм-ийн диаметртай цооногийг голын доогуур хөндлөн өрөмдөж гаргаж байгаа гэсэн үг. 1400 мм-ийн диаметртай ган хоолойг энэ өрөмдлөгийн машинтайгаа хамт явуулаад тавьчихсан байгаа. Дараа нь яг усаа дамжуулах уян ширмэн хоолойгоо тэр дотроо тавих юм.

-238 метрийг газрыг хэчнээн хоногт өрөмдсөн бэ. Яг товлосон цэгээрээ гарч ирэв үү?

-Өдөрт дунджаар 8 метр гаруй урагшилж байсан. Анхны туршлага



болохоор өөр газраар гараад ирэх вий гэж нэлээд эргэлзэж байсан. 28 хоногийн дараа яг л тодорхойлсон цэгээрээ гарч ирсэн. Одоо нөгөө хос шугамынх нь өрөмдлөг яг зэрэгцээ яваад, эхний энэ сүвлэгээний ажлаа 5 дугаар сарын эхээр бүрэн дуусгахаар төлөвлөж байна.

Шинэ эх үүсвэрийн худгаасаа хэчнээн ус татаж авсан ч энэ сүвлэгээг хийхгүйгээр үйлдвэр рүүгээ ус хүргэж чадахгүй гэсэн үг. Сүвлэгээгээ дуусгаад, шугамаа тавьчихвал 6 дугаар сардаа багтаад Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр рүү энэ шугамаараа дамжуулаад усаа өгөх боломжтой болох юм.

ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ("ХУДБҮ") болон дахин боловсруулсан усыг "ДЦС-3", "ДЦС-4" ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжснээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл шоо метрээр бууруулах юм.


Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 75.4%-д хүрэв

Түрүүч нь 1-р нүүрт

үргэлжилж байна. Технологийн есөн байгууламжаас хаягдал ус хүлээн авах худгийн барилгын ажил бүрэн дууссан, шахуургын станц №1 79.8%, тогтворжуулах сан 82%, хөдөлгөөнт био реактор 61%, ламелла тунгаагуурын байгууламжийн барилгын ажлын явц 67.3%-ийн гүйцэтгэлтэй байгаа бол ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилгын ажил 44.8%, халдваргүйжүүлэх сан 84.8%, шахуургын станц №2 73.4%, ус зайлуулах сангийн барилга угсралт 51.44%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.



Дунд голыг хөндлөн сүвлэж, 150 метр урт шугам хоолой тавих ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ



Хаягдал ус дахин боловсруулах төслийн нэг гол бүрэлдэхүүн хэсэг болох Дахин боловсруулсан ус дамжуулах систем,

ДЦС-уудын өөрчлөлтийн ажлын нийт гүйцэтгэл 71%-д хүрэв. Энэ хүрээнд Дунд голыг хөндлөн сүвлэж 150 метр урт шугам хоолой тавих ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Түүнчлэн Өргөлтийн насос станцаас ДЦС-3 ТӨХК хүртэлх 500м голчтой 1.48 км шугам хоолойг угсарч суурилуулах ажил 81.1%, Салаалах худгаас Өргөлтийн насос станц хүртэлх 700мм голчтой шугам хоолой суурилуулах ажлын гүйцэтгэл 31.5% гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Товчхон



Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрээс ДЦС-уудад нийлүүлэх дахин ашиглах цэвэрлэсэн усанд тавигдах техникийн шаардлагын MNS 6734:2018 стандартад оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж, санал солилцох уулзалтыг 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр холбогдох салбарын яам, агентлаг, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан зохион байгууллаа.

Түрүүч нь 1-р нүүрт

УСУГ-ын инженер, техникийн ажилтнуудад зориулсан онол, дадлагын сургалт эхэллээ

Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар (УСУГ)-ын Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажилтнуудад зориулсан сургалт 2025 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр дээр эхэллээ. Сургалтад 20 гаруй инженер, техникийн ажилтан хамрагдаж байгаа бөгөөд сургалт, дадлагын эхний хэсэг үйлдвэрийн туршилт, тохируулгын эхний үе шаттай уялдан явагдаж, 5 дугаар сарын 15-ныг хүртэл үргэлжлэх юм.

Цаашид эдгээр ажилтнууд үйлдвэрийн туршилт тохируулгын гурван үе шатыг дуустал сургалтад хамрагдаж, 2 дахь үе шатнаас эхлэн бүтэн жилийн хугацаанд "МАПА Иншаат вэ Тиажарет" компанийн инженерүүд, сургагч багш нарыг дагалдан Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг ажиллуулахад дадлагажих юм.



ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Гэр хорооллын 180 ус түгээх байрыг бүрэн автоматжуулж, баталгаат засвар, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна

Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын гэр хороолол дахь төвийн шугамд холбогдсон 6 дүүргийн 180 ус түгээх байрыг 24 цагийн ажиллагаатай болгож, бүрэн автоматжуулж байгаа бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 98%-тай үргэлжилж байна. Энэ ажлын хүрээнд ус түгээх байруудын нэгдсэн хяналт удирдлагын системийн хөгжүүлэлт, туршилт, нэвтрүүлэлт, дотор, гадна цахилгаан хангамж болон үзелийн шинэчлэл, гадна тохижилтын ажлуудыг бүрэн хийж дуусгалаа. Одоогоор баталгаат засвар, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.



Зургаан удаагийн сургалтын аялалд нийт 104 инженер, техникийн ажилтныг хамрууллаа

Нидерландын Вант Улсын усны ашиглалтын байгууллагатай харилцан мэдлэг, туршлага солилцох замаар УСУГ-ын инженер, техникийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх Усны ашиглалтын байгууллагын түншлэлийн хөтөлбөрийг 2023-2025 оны хооронд хэрэгжүүлж байна. Одоогоор будаагийн сургалтын аяллыг Нидерланд улсад зохион байгуулж, нийт 104 ажилтныг хамруулсан бол Нидерландын усны нарийн мэргэжлийн 10 гаруй инженер УСУГ-т 4 удаа биечлэн ирж мэдлэг туршлагаа хуваалцав.



Усны үйлчилгээний хэрэглэгчийн мэдээллийн сан бүхий системийн альфа хувилбарыг хөгжүүлэв

Түрүүч нь 1-р нүүрт бүхий системийн альфа хувилбарыг хөгжүүлээд байна. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулж, иргэдийн төлбөр төлөх эрмэлзлийг нэмэгдүүлэх зорилго бүхий энэхүү цогц цахим системийг хөгжүүлснээр нийслэлийн иргэдийн өдөр тутмын ажлыг илүү хялбарчлах ач холбогдолтой төдийгүй Улаанбаатар хотын хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн байгууллагуудыг нэгдсэн стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх, хэрэглэгчдэд өрхийн усны хэрэглээ, төлбөр, усны хязгаарлалт болон бусад үйлчилгээтэй холбоотой мэдээллийг цаг тухайд нь өгөх боломж бүрдэх юм.

“Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх Ажлын хэсгийн өргөтгөсөн хурал боллоо



“Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх

Ажлын хэсгийн өргөтгөсөн хурал 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр шинэ ТЦБ-ийн хурлын танхимд боллоо.

Хуралд Ажлын хэсгийн гишүүд, Монголын МСС болон Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн нэгжийн төлөөлөл оролцов. Хурлаар тус төлөвлөгөөний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замууд, төлөвлөгөөг олон нийтэд сурталчлан таниулах аяны талаар хэлэлцэж, шинэ ШТБ болон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр байгуулах төслийн явцтай танилцлаа.

Товчхон

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор нийт 40 гаруй контент бэлтгэн түгээхээр ажиллаж байна

Компакт гэрээ хэрэгжиж дуусахад

1 жил 0 сар

үлдлээ